



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2014 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/943

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газарт шилмүүст болон навчит модны үр, мөчир, үржүүлэх “Хүлэмж” худалдан авах ажил, Мод үржүүлгийн газрын усалгааны систем шинэчлэх зэрэг ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Очирхуяг (Сум дундын Ойн ангийн дарга)
Гишүүд: Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)
Ц.Амгалан (Ойн ангийн техникч)
Ш.Бумандолгор (Ойн ангийн инженер)
А.Мягмардагва (Ойн ангийн инженер)

2.Худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтыг боловсруулан 3-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжээс үнийн санал авч нийлүүлэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Очирхуяг)-д даалгасугай.

ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

